БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/78/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот 2019 он


Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: Б.Азбаяр

Утас: 99061429 Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |

## Агуулга


1 Аудитын гэрчилгээ ... 3

2 Аудитын тайлан ... 5

2.1 Оршил ... 5

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ... 5

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ... 6

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ... 6

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ... 7

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ... 7

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ... 8

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ... 8

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ... 10

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ... 10

2.11 Шилэн дансны мэдээлэл ... 10

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ... 10

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ... 11

3 Менежментийн захидал ... 12

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан ... 13

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ... 13

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ... 14

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ... 16

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ... 18

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 19

# 1 Аудитын гэрчилгээ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2019.02.20 № 2/17

танай ________ -ны № ________ т

БАЯНХОНГОР АЙМГИЙН
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГА
Н.БАТТОГТОХ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2518499

E:\ajil\2019 on\STA 2018\4. Negdsen emneleg\4. Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

E:\ajil\2019 on\STA 2018\4. Negdsen emneleg\4. Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

# 2 АУДИТЫН ТАЙЛАН

## 2.1 ОРШИЛ

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Нэгдсэн эмнэлгийн дарга Баттогтох-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.25-наас 2019.02.20–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын Б. Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.01.25-ны өдрийн №24 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

## 2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний жишигт нийцсэн үйл ажиллагаатай орчин үеийн тэвшилтэд технологийг тасралтгүй нэвтрүүлсэн салбартаа найдвартай нэр хүнд бүхий тэргүүлэгч эмнэлэг байх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нэгдсэн эмнэлэг нь долоогоос доошгүй үндсэн мэргэшлээр эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг амбулаториор болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх байгууллага байна.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль

- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

## 2.5 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон аудитор гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “"Санхүүгийн тооцоолох" ХХК-ийн ACOULOUS ” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

## 2.6 ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД ТОДОРХОЙЛСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Аудитын явцад Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7

асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь аккруэль сууриар бэлтгэгдсэн санхүүгийн тайлангийн хувьд дээрх үзүүлэлтийг суурь болгож авах нь зүйтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2018 оны *Нийт зардал* 7875664,1 мянган төгрөг бөгөөд түүний *2* хувь болох *157,513.*3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг *2* хувиар тооцсон нь эрсдлийн үнэлгээ дунд байгаатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн. Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Зөвлөмж өгсөн | 1 | 8,536.20 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 2 | 3,944.20 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 0 | 0.00 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| | Дүн | 3 | 12,480.40 | |

## 2.8.1 ЗӨВЛӨМЖ ӨГӨХӨӨС БУСАД ХЭЛБЭРЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

1. Татварын хөнгөлөлтийг жилийн дүнгээр тооцож залруулга хийгээгүйгээс 1726.8 мянган төгрөгийн ХХОАТ-ын хөнгөлөлтийг дутуу суутгасан.

2. Нийгмийн даатгалын тайлангийн цалин түүнтэй адилтгах орлогыг 1188580 төгрөгөөр илүү мэдээлсэнээс 273.4 мянган төгрөгийг илүү төлсөн.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоох

2.8.1.2 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

1.Хөдөлмөр хамгааллын зардлаас Барилгын хөгжлийн төвд 2018.02.13-нд 1944.0 мянган төгрөгийн магадлалын хөлсийг шилжүүлж шууд зардалд бичсэн.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16.5.5-д заасан "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоох

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

## 2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2.9.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Ариутгал угаалгын барилга”-ыг барьсан ба одоогоор эмийн сангийн зориулалтаар ашиглаж байгаа бөгөөд тус барилгыг аймгийн Эрүүл мэндийн газрын 2019.02.19-ний өдрийн №86 тоот албан бичгээр “улсын комисс хүлээн аваагүй” гэсэн тайлбар өгсөн тул дараагийн аудитаар анхаарч авч үзэх шаардлагатай. Энэхүү хөрөнгө оруулалт нь анх төлөвлөгдсөн хэрэгцээ шаардлагын дагуу ашиглагдаагүй байгаа нь төсвийн хөрөнгийн үр ашиг гараагүй байна.

## 2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 7 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 6620022.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 6616598,5 мянган төгрөг буюу 99,9 хувь бөгөөд 3,3 сая төгрөг хэмнэлт гарсан нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал /гэрэл цахилгаан/ байна.

## 2.11 Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу тогтоосон хугацаанд мэдээлбэл зохих 25 мэдээг хугацаанд нь бүрэн байршуулсан байна. Харин 7 хоногийн дотор мэдээлбэл зохих 12918.0 сая төгрөгийн 278 мэдээнээс 1280.6 сая төгрөгийн 17 гүйлгээг цахим сайтад байршуулаагүй байсныг шилэн дансны нийцлийн аудитаар албан шаардлага өгч зөрчлийг арилгасан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биеэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## 2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай биелэсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## 2.13 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

# 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд орших буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн

3.1.1 Илрүүлэлт:

- Кассын орлогоос 8536.2 мянган төгрөгийг Төрийн сангийн дансанд тушаалгүйгээр шууд зарцуулсан.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам" -ын 2.6-д заасан " Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" тус тус зөрчсөн.

**3.1.2 Эрсдэл:**

Тайлант хугацаанд бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламжийг нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлд бүрэн тусгаагүй нуун дарагдуулсан байх

**3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 3.12 дахь заалтыг мөрдөж ажиллах

**3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Саналгүй

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019.06.15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **496,216,220.22** | **583,885,739.33** |
| **33** | **АВЛАГА** | 6,580,399.62 | 5,283,795.62 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 836,604.00 | 00.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 967,829.62 | 967,829.62 |
| **335** | **Бусад авлага** | 4,775,966.00 | 4,315,966.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 4,775,966.00 | 4,315,966.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 489,635,820.60 | 578,601,943.71 |
| **351** | **Түүхий эд материал** | 189,561,139.27 | 275,847,574.14 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 61,361,403.00 | 93,604,958.98 |
| 35130 | Эм боох материал | 128,199,736.27 | 182,242,615.16 |
| **354** | **Хангамжийн материал** | 300,074,681.33 | 302,754,369.57 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 115,000.00 | 710,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,640,124.46 | 8,294,106.52 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 6,908,880.25 | 5,915,181.24 |
| 35450 | Барилгын засварын материал | 10,130,178.00 | 2,676,984.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,000,643.81 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 265,279,854.81 | 285,158,097.81 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **7,465,425,171.92** | **8,771,751,127.81** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 7,465,425,171.92 | 8,771,751,127.81 |
| **392** | **Биет хөрөнгө** | 7,464,877,736.51 | 7,323,683,129.88 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 9,287,312,730.84 | 5,112,638,500.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -4,346,680,702.20 | 00.00 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 376,886,171.37 | 348,281,277.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -278,735,182.93 | -219,392,770.42 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 5,261,541,003.42 | 5,937,933,974.21 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -2,949,827,125.26 | -3,964,330,787.98 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 670,915,202.82 | 456,408,724.74 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -556,534,361.55 | -347,855,787.67 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 547,435.41 | 1,448,067,997.93 |
| 39301 | Програм хангамж | 5,146,900.00 | 5,146,900.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -4,599,464.59 | -4,903,902.07 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,092,000.00 | 1,448,917,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -1,092,000.00 | -1,092,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **7,961,641,392.14** | **9,355,636,867.14** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **7,961,641,392.14** | **9,355,636,867.14** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 7,961,641,392.14 | 9,355,636,867.14 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 5,277,991,344.70 | 6,725,816,344.70 |
| 51101 | Өмч: - төрийн | 5,277,991,344.70 | 6,725,816,344.70 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -251,586,299.56 | -512,631,185.94 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -251,586,299.56 | -244,044,254.56 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -268,586,931.38 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,935,236,347.00 | 3,142,451,708.38 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 7,961,641,392.14 | 9,355,636,867.14 |

## 4.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **7,047,576,212.95** | **7,521,964,109.48** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **178,872,356.00** | **696,628,091.48** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 178,872,356.00 | 325,544,708.98 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 178,872,356.00 | 325,544,708.98 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 163,411,146.00 | 147,397,483.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 15,461,210.00 | 178,147,225.98 |
| **122** | **Тусламжийн орлого** | 00.00 | 371,083,382.50 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 00.00 | 101,966,685.50 |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | 00.00 | 269,116,697.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **6,868,703,856.95** | **6,820,539,414.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 3,121,544,934.00 | 3,211,882,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,091,808,500.00 | 3,211,882,300.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 29,736,434.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 102,511,340.62 | 350,288,521.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 31,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 43,748,894.00 | 82,971,417.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 56,415,200.00 | 235,817,104.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | 2,347,246.62 | 00.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 333,448,560.33 | 00.00 |
| 133003 | Хөрөнгийн | 333,448,560.33 | 00.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 3,311,199,022.00 | 3,263,165,197.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 67,267,424.00 | 00.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 3,243,931,598.00 | 3,263,165,197.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **7,528,569,952.80** | **7,790,497,635.21** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **7,528,569,952.80** | **7,790,497,635.21** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 7,280,030,181.80 | 7,700,822,465.25 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,608,212,950.00 | 3,799,442,446.00 |
| 210101 | Үндсэн цалин | 3,603,936,312.00 | 3,799,442,446.00 |
| 210102 | Нэмэгдэл | 4,276,638.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 401,157,900.00 | 457,795,304.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 401,157,900.00 | 307,650,761.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 37,153,333.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 31,792,288.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 7,381,721.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 73,817,201.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 671,508,719.00 | 719,738,762.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 63,585,175.00 | 68,343,408.00 |
| 210302 | Түлш, халаалт | 499,382,200.00 | 542,492,285.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 108,541,344.00 | 108,903,069.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 218,163,871.34 | 157,248,305.94 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 5,367,650.00 | 27,151,006.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 78,457,680.00 | 68,184,755.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,003,867.00 | 10,065,857.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 48,650,033.48 | 51,521,687.94 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,627,246.62 | 325,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 69,057,394.24 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,462,416,712.18 | 1,513,241,427.96 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,254,496,299.68 | 1,293,487,254.15 |
| 210502 | Хоол, хүнс | 207,920,412.50 | 183,822,173.81 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 35,932,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 51,043,129.57 | 80,337,867.01 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,773,000.00 | 730,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 4,276,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 49,270,129.57 | 75,331,467.01 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 23,549,923.00 | 20,498,660.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 23,549,923.00 | 20,498,660.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 48,919,867.00 | 52,072,472.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 25,042,417.00 | 47,650,464.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,980,000.00 | 1,980,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 623,700.00 | 623,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 712,800.00 | 1,398,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 275,000.00 | 255,178.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,713,200.00 | 00.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 85,000.00 | 00.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 18,487,750.00 | 165,030.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 795,057,109.71 | 900,447,220.34 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 795,057,109.71 | 900,447,220.34 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 248,539,771.00 | 89,675,169.96 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 218,522,818.00 | 89,403,854.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 67,267,424.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 43,748,894.00 | 82,362,354.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 107,506,500.00 | 7,041,500.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 271,315.96 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 271,315.96 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 30,016,953.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 30,016,953.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-480,993,739.85** | **-268,533,525.73** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 53,405.65 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 50,906.25 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 00.00 | 2,499.40 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -53,405.65 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-480,993,739.85** | **-268,586,931.38** |

## 4.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **6,668,930,008.62** | **6,972,733,501.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **163,411,146.00** | **147,397,483.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 163,411,146.00 | 147,397,483.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 163,411,146.00 | 147,397,483.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 163,411,146.00 | 147,397,483.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **6,505,518,862.62** | **6,825,336,018.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 3,091,808,500.00 | 3,211,882,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,091,808,500.00 | 3,211,882,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 102,511,340.62 | 350,288,521.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 31,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 43,748,894.00 | 82,971,417.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 56,415,200.00 | 235,817,104.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | 2,347,246.62 | 00.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 3,311,199,022.00 | 3,263,165,197.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 67,267,424.00 | 00.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 3,243,931,598.00 | 3,263,165,197.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **6,668,930,008.62** | **6,939,628,601.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,668,930,008.62** | **6,939,628,601.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **6,419,422,408.00** | **6,856,994,931.04** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,611,902,950.00 | 3,679,333,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 2,185,928,050.00 | 1,945,148,800.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,052,206,200.00 | 1,371,182,900.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 65,078,600.00 | 177,144,000.00 |
| 210104 | Урамшуулал | 308,690,100.00 | 185,858,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 397,467,900.00 | 440,320,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 397,467,900.00 | 293,546,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 36,693,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 29,354,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 7,338,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 73,386,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 671,508,719.00 | 719,738,762.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 63,585,175.00 | 68,343,408.00 |
| 210302 | Түлш, халаалт | 499,382,200.00 | 542,492,285.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 108,541,344.00 | 108,903,069.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 160,494,987.00 | 155,369,135.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,146,500.00 | 8,336,668.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 76,796,680.00 | 66,388,690.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,003,867.00 | 10,065,857.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 38,757,240.00 | 40,558,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 26,790,700.00 | 30,019,120.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,412,554,517.00 | 1,486,020,529.04 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,174,720,861.00 | 1,283,194,999.04 |
| 210502 | Хоол, хүнс | 205,653,656.00 | 179,821,530.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 32,180,000.00 | 23,004,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 63,852,195.00 | 55,280,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,126,455.00 | 7,340,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,960,000.00 | 11,454,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 47,765,740.00 | 36,486,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 23,549,923.00 | 17,894,660.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 23,549,923.00 | 17,894,660.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 78,091,217.00 | 303,037,045.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 56,347,617.00 | 282,426,167.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,980,000.00 | 1,980,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 623,700.00 | 623,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 712,800.00 | 1,398,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 275,000.00 | 255,178.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,713,200.00 | 00.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 85,000.00 | 00.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 16,353,900.00 | 16,353,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **249,507,600.62** | **82,633,669.96** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 218,522,818.00 | 82,362,354.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 67,267,424.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 43,748,894.00 | 82,362,354.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 107,506,500.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 271,315.96 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 271,315.96 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 30,016,953.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 30,016,953.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 967,829.62 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 967,829.62 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **33,104,900.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **33,104,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **33,104,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 33,104,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 33,104,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-33,104,900.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 4.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| D01 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,277,991,344.70** | **2,935,236,347.00** | **-251,586,299.56** | **00.00** | 7,961,641,392.14 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 7,542,045.00 | 00.00 | 7,542,045.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **5,277,991,344.70** | **2,935,236,347.00** | **-244,044,254.56** | **00.00** | 7,969,183,437.14 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 207,215,361.38 | 00.00 | 00.00 | 207,215,361.38 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 1,447,825,000.00 | 00.00 | -268,586,931.38 | 00.00 | 1,179,238,068.62 |
| D09 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **6,725,816,344.70** | **3,142,451,708.38** | **-512,631,185.94** | **00.00** | 9,355,636,867.14 |

## 4.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 6,470,616,800.00 | 6,467,421,091.00 | 6,620,022,900.00 | 6,622,173,664.04 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 6,470,616,800.00 | 6,467,421,091.00 | 6,620,022,900.00 | 6,622,173,664.04 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 6,362,016,800.00 | 6,359,914,591.00 | 6,620,022,900.00 | 6,622,173,664.04 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,613,344,800.00 | 3,611,902,950.00 | 3,679,333,900.00 | 3,679,333,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 2,187,369,900.00 | 2,185,928,050.00 | 1,945,148,800.00 | 1,945,148,800.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,052,206,200.00 | 1,052,206,200.00 | 1,371,182,900.00 | 1,371,182,900.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 65,078,600.00 | 65,078,600.00 | 177,144,000.00 | 177,144,000.00 |
| 210104 | Урамшуулал | 308,690,100.00 | 308,690,100.00 | 185,858,200.00 | 185,858,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 397,467,900.00 | 397,467,900.00 | 440,320,100.00 | 440,320,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 397,467,900.00 | 397,467,900.00 | 293,546,700.00 | 293,546,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 00.00 | 36,693,300.00 | 36,693,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 00.00 | 29,354,700.00 | 29,354,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 00.00 | 7,338,700.00 | 7,338,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 00.00 | 73,386,700.00 | 73,386,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 671,508,900.00 | 671,508,719.00 | 723,018,300.00 | 719,738,762.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 58,606,900.00 | 63,585,175.00 | 71,916,700.00 | 68,343,408.00 |
| 210302 | Түлш, халаалт | 504,292,600.00 | 499,382,200.00 | 542,492,200.00 | 542,492,285.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 108,609,400.00 | 108,541,344.00 | 108,609,400.00 | 108,903,069.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 160,387,000.00 | 160,494,987.00 | 160,538,700.00 | 160,559,035.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,340,800.00 | 6,146,500.00 | 7,340,800.00 | 8,336,668.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 70,407,100.00 | 76,796,680.00 | 64,907,100.00 | 66,388,690.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,146,000.00 | 12,003,867.00 | 12,146,000.00 | 10,065,857.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 34,681,300.00 | 38,757,240.00 | 40,333,800.00 | 40,558,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 35,811,800.00 | 26,790,700.00 | 35,811,000.00 | 35,209,020.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,396,206,300.00 | 1,395,766,517.00 | 1,499,231,200.00 | 1,499,225,529.04 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,183,375,100.00 | 1,157,932,861.00 | 1,296,400,000.00 | 1,296,399,999.04 |
| 210502 | Хоол, хүнс | 189,822,100.00 | 205,653,656.00 | 179,822,100.00 | 179,821,530.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 23,009,100.00 | 32,180,000.00 | 23,009,100.00 | 23,004,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 63,940,800.00 | 63,852,195.00 | 63,940,800.00 | 69,490,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,000,000.00 | 12,126,455.00 | 20,000,000.00 | 21,550,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 23,004,300.00 | 3,960,000.00 | 13,004,300.00 | 11,454,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 30,936,500.00 | 47,765,740.00 | 30,936,500.00 | 36,486,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 23,681,500.00 | 23,549,923.00 | 18,029,000.00 | 17,894,660.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 23,681,500.00 | 23,549,923.00 | 18,029,000.00 | 17,894,660.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 35,479,600.00 | 35,371,400.00 | 35,610,900.00 | 35,610,878.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил | 14,641,000.00 | 15,341,000.00 | 15,000,000.00 | 15,000,000.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний төлбөр хураамж | | | | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,980,000.00 | 1,980,000.00 | 1,980,000.00 | 1,980,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 623,700.00 | 623,700.00 | 623,700.00 | 623,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 712,800.00 | 712,800.00 | 1,398,100.00 | 1,398,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 351,500.00 | 275,000.00 | 255,200.00 | 255,178.00 |
| 210807 | Газрын төлбөр | 519,700.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 297,000.00 | 85,000.00 | 00.00 | 00.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 16,353,900.00 | 16,353,900.00 | 16,353,900.00 | 16,353,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 108600000.00 | 107506500.00 | 0.00 | 0.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 108,600,000.00 | 107,506,500.00 | 00.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 108,600,000.00 | 107,506,500.00 | 00.00 | 00.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 6,470,616,800.00 | 6,467,421,091.00 | 6,620,022,900.00 | 6,622,173,664.04 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,091,808,500.00 | 3,061,791,547.00 | 3,211,882,300.00 | 3,211,610,984.04 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,091,808,500.00 | 3,061,791,547.00 | 3,211,882,300.00 | 3,211,610,984.04 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,243,937,000.00 | 3,243,931,598.00 | 3,263,269,600.00 | 3,263,165,197.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 3,243,937,000.00 | 3,243,931,598.00 | 3,263,269,600.00 | 3,263,165,197.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 134,871,300.00 | 161,697,946.00 | 144,871,000.00 | 147,397,483.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 134,871,300.00 | 161,697,946.00 | 144,871,000.00 | 147,397,483.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 282.00 | 366.00 | 292.00 | 366.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 02.00 | 02.00 | 02.00 | 02.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 180.00 | 264.00 | 190.00 | 264.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 100.00 | 100.00 | 100.00 | 100.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **282.00** | **366.00** | **292.00** | **366.00** |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 242.00 | 323.00 | 242.00 | 323.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 40.00 | 43.00 | 50.00 | 43.00 |